



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/74/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах Аудитор Д.Цэрэнханд Утас: 99147999 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
4. Аудитын илрүүлэлт .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г.ЧҮЛТЭМЖАМЦ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.01.17 № 03

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020039

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл


### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>23,939,917.00</u></b>	<b><u>60,674,340.70</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	23,939,917.00	60,674,340.70
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	8,545,317.00	13,812,555.70
35110	Тусгай зориулалттай материал	8,545,317.00	13,812,555.70
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,234,670.00	16,093,850.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,159,930.00	30,767,935.00
35410	Бичиг хэргийн материал	994,940.00	256,500.00
35420	Аж ахуйн материал	3,783,800.00	12,709,245.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	55,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,381,190.00	17,747,190.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>150,801,062.94</u></b>	<b><u>283,915,475.53</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	150,801,062.94	283,915,475.53
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	147,401,062.94	281,648,808.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	50,567,600.00	50,567,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,106,983.28)	(3,160,474.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,500,000.00	8,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(4,250,000.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,439,346.00	291,262,156.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,296,375.55)	(65,588,405.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,505,200.00	18,018,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,207,724.23)	(13,700,166.95)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,400,000.00	2,266,666.72
39301	Програм хангамж	3,400,000.00	3,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,133,333.28)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>174,740,979.94</u></b>	<b><u>344,589,816.23</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>174,740,979.94</u></b>	<b><u>344,589,816.23</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	174,740,979.94	344,589,816.23
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	137,248,004.73	307,096,841.02
51210	Өмнөх үеийн үр дүн	137,248,004.73	137,248,004.73
51220	Тайлант үеийн үр дүн	-	169,848,836.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,492,975.21	37,492,975.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>174,740,979.94</u></b>	<b><u>344,589,816.23</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>737,997,521.55</b>	<b>834,084,615.34</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>103,814,521.55</b>	<b>243,321,315.34</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	103,814,521.55	243,321,315.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,814,521.55	243,321,315.34
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	103,814,521.55	243,321,315.34
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>634,183,000.00</b>	<b>590,763,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		


ГАА-2022/74/НА-СТА-ТШЗ



Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

		482,497,600.00	501,166,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	482,497,600.00	501,166,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	151,685,400.00	89,597,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	151,685,400.00	82,097,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>651,504,735.11</b>	<b>664,235,779.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>651,504,735.11</b>	<b>664,235,779.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	651,111,135.11	663,874,244.05
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	405,269,600.00	419,832,925.00
210101	Үндсэн цалин	312,672,562.00	332,909,808.00
210102	Нэмэгдэл	84,589,718.00	78,708,960.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,007,320.00	8,214,157.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	51,143,100.00	54,153,840.00
210201	Тэтгэврийн даатгал	35,509,469.00	38,239,815.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,174,495.00	4,257,130.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,258,956.00	3,365,383.00
210204	Ажилгүйдлийн даатгал	745,471.00	753,773.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,454,709.00	7,537,739.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,143,100.00	7,523,100.00
210302	Түлш, халаалт	303,000.00	564,600.00
210304	Байрны түрээс	5,798,800.00	6,958,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,000,724.85	17,397,492.00
210401	Бичиг хэрэг	8,439,775.00	8,483,340.00
210402	Тээвэр, шатахуун	1,594,200.00	1,774,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,668,500.00	1,602,411.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,000.00	210,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,440,666.55	3,446,464.00
210408	Бараа материал акталсны зардал	820,583.30	1,880,597.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,666,800.00	14,532,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	766,800.00	14,057,000.00
210604	Урсгал засвар	900,000.00	475,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	342,000.00	228,800.00
210702	Дотоод албан томилолт	342,000.00	228,800.00

ГАА-2022/74/НА-СТА-ТШЗ




**Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,522,060.00	10,031,004.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,472,000.00	2,409,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,788,060.00	7,360,004.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	161,023,750.26	140,175,082.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	151,685,400.00	82,097,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,164,800.00	858,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,173,550.26	57,220,082.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	393,600.00	361,535.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	393,600.00	316,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	393,600.00	316,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	44,735.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,735.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>86,492,786.44</b>	<b>169,848,836.29</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	39,491,830.39	00.00	39,491,830.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	37,492,975.21	00.00	00.00	37,492,975.21
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	8,723,741.38	00.00	8,723,741.38
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>37,492,975.21</b>	<b>137,248,004.73</b>	<b>00.00</b>	174,740,979.94
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>37,492,975.21</b>	<b>137,248,004.73</b>	<b>00.00</b>	174,740,979.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>37,492,975.21</b>	<b>137,248,004.73</b>	<b>00.00</b>	174,740,979.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00



D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	169,848,836.29	00.00	169,848,836.29
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>37,492,975.21</b>	<b>307,096,841.02</b>	<b>00.00</b>	<b>344,589,816.23</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>731,032,408.30</b>	<b>709,782,687.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>96,849,408.30</b>	<b>119,019,387.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	96,849,408.30	119,019,387.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	96,849,408.30	119,019,387.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	96,849,408.30	119,019,387.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>634,183,000.00</b>	<b>590,763,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	482,497,600.00	501,166,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	482,497,600.00	501,166,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	151,685,400.00	89,597,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	151,685,400.00	82,097,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>729,436,908.30</b>	<b>708,607,687.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>729,436,908.30</b>	<b>708,607,687.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>632,193,900.00</b>	<b>589,226,765.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	405,269,600.00	419,832,925.00
210101	Үндсэн цалин	312,672,562.00	331,030,572.00
210102	Нэмэгдэл	84,589,718.00	80,797,766.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,007,320.00	8,004,587.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	51,143,100.00	54,153,840.00
210201	Тэтгэврийн даатгал	34,797,000.00	38,637,440.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,086,500.00	3,879,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,269,200.00	3,103,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	817,300.00	775,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,173,100.00	7,758,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,143,100.00	7,523,100.00
210302	Түлш, халаалт	303,000.00	564,600.00
210304	Байрны түрээс	5,798,800.00	6,958,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,245,100.00	12,962,100.00
210401	Бичиг хэрэг	6,115,200.00	5,890,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,594,200.00	1,774,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,668,500.00	1,602,411.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,000.00	210,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,830,200.00	3,484,709.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,466,800.00	8,900,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	7,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	766,800.00	1,125,000.00
210604	Урсгал засвар	700,000.00	275,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	342,000.00	228,800.00
210702	Дотоод албан томилолт	342,000.00	228,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,734,000.00	2,671,000.00

**Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,472,000.00	2,409,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>152,850,200.00</b>	<b>82,955,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	151,685,400.00	82,097,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,164,800.00	858,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>97,243,008.30</b>	<b>119,380,922.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>393,600.00</b>	<b>316,800.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	393,600.00	316,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>96,849,408.30</b>	<b>119,064,122.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,735.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,595,500.00</b>	<b>1,175,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,595,500.00</b>	<b>1,175,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,595,500.00</b>	<b>1,175,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,595,500.00</b>	<b>1,175,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,595,500.00	1,175,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,595,500.00)</b>	<b>(1,175,000.00)</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	501,166,300.00	501,121,565.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	501,166,300.00	501,121,565.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	500,849,500.00	500,804,765.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	419,842,200.00	419,832,925.00
210101	Үндсэн цалин	341,896,800.00	331,030,572.00
210102	Нэмэгдэл	69,103,400.00	80,797,766.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,842,000.00	8,004,587.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	54,189,300.00	54,153,840.00
210201	Тэтгэврийн даатгал	38,672,900.00	38,637,440.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,879,100.00	3,879,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,103,300.00	3,103,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	775,800.00	775,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,758,200.00	7,758,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,523,100.00	7,523,100.00
210302	Түлш, халаалт	572,300.00	564,600.00
210304	Байрны түрээс	6,818,000.00	6,958,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,962,100.00	12,962,100.00
210401	Бичиг хэрэг	5,220,800.00	5,890,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,402,000.00	1,774,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,754,000.00	1,602,411.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,500.00	210,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,542,800.00	3,484,709.00



<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,575,000.00	2,575,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,175,000.00	1,175,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,125,000.00	1,125,000.00
210604	Урсгал засвар	275,000.00	275,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	228,800.00	228,800.00
210702	Дотоод албан томилолт	228,800.00	228,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,671,000.00	2,671,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,409,000.00	2,409,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	858000.00	858000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	858,000.00	858,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	316800.00	316800.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	316,800.00	316,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	316,800.00	316,800.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	501,166,300.00	501,121,565.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	501,166,300.00	501,121,565.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	501,166,300.00	501,121,565.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>89,597,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>89,597,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	89,597,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	82,097,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,097,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>89,597,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	89,597,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,097,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон

аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 50 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит тогтмол хийж, үр дүнг сайжруулан, Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулав.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлийг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 651.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 10.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 664.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 11.0 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50 хувиар буюу 169.8 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 60.6 сая төгрөг болж 36.7 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал, түүхий эд материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 27.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 54.2 сая төгрөгийн бараа материал авч, үйл ажиллагаандаа 43.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 60.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 371.7 сая төгрөг болж 191.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1.17 сая төгрөг, УБЕГ-аас 188.1 сая төгрөгийн, 3.9 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, элэгдлийн хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлж 0.7 сая төгрөг нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 344.6 сая төгрөг болж 169.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 13 хувиар буюу 96.0 сая төгрөгөөр өссөн нь УБЕГ-аас үнэ төлбөргүй хөрөнгө ирсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 307.0 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 576.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 75.1 сая төгрөгөөр бууруулж, 501.16 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг 501.1 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 501.16 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 501.12 сая төгрөгийг зарцуулж 0.04 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 501.12 сая төгрөг буюу 100 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 0.009 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.035 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

ГАА-2022/74/НА-СТА-ТШЗ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ЗДТГ-аас сонгуультай холбоотой 7.5 сая төгрөг, УБЕГ-аас 82.0 сая төгрөгийн нийт 89.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, 82.0 сая төгрөгийн бараа үйлчилгээний бусад /сонгууль зохион байгуулах/ зардалд, 7.5 сая төгрөгийг багаж техник хэрэгсэл худалдан авахад зарцуулжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 417.3 сая төгрөгийн 76 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 417.3 сая төгрөгийн 76 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд 2.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг илүү дутуу шивүүлснийг аудитын явцад залрууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.6 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараа жилийн аудитаар төсвийн хэмнэлтийн горим, бараа материалын тайлангийн тулгалтыг шалгах нь зүйтэй.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.2 сая төгрөгийн алдааг залруулж, 0.24 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

##### 4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 2.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг илүү дутуу шивүүлснийг аудитын явцад залрууллаа

##### 4.2 Төлбөрийн акт

Ажиллагсдын амралтын цалин 0.23 сая төгрөгийг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтооллоо.

##### 4.3 Албан шаардлага

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 6.5 сая төгрөгийг бараа материалын тайланд орлого авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ.

Сумдын байцаагч нарын үнэт цаас 1.9 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн 0.055 сая төгрөгийг тоолоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10 аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй, цайны материалд 1.3 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын..."үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ.


##### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

**1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улсын бүртгэлийн хэлтэс	5	12.2	1	2.2	1	0.23	3	9.7		
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>12.2</b>	<b>1</b>	<b>2.2</b>	<b>1</b>	<b>0.23</b>	<b>3</b>	<b>9.7</b>		



Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Улсын бүртгэлийн хэлтсийн СТА Аудитын код: ГАА-2022/74-Н  
 Байгууллагын нэр: УБХ

№	Төлөөлөгч буй АГАДУТ-н дэд анги	Товч утга	Мөнгөн дүн	Материалл аг эсэх	Үр өгөөжөөр тооцож эсэх	Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт	Шалгуур	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалтгаалгүй байгууллагын мэдээлэл	Аудитын байгууллагын эсрэг аргаар	Гаргасан шийдэл
1	Ажил гүйцэтгэлийн зардал анги	Ажиллагсдын амралтын цалин 237.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон	237.01	237.01	237.01	УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4	Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2-т "Ажилтан Үндсэн ажлынхаа зэрэгцээ мэрэгжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй орлон гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно", /тогтоосон шийдвэр/	Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно	Төлбөрийн акт	<i>Хүрэн</i>		
2	Ажил гүйцэтгэлийн хөрөнгө анги	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 6,500.0 мянган төгрөгийг бараа материалыг тайланд орлого авсан	6,500.00			УСНББОУС-1, 39, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4	Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно	Албан шаардлага	<i>Хүрэн</i>			
3	Ажил гүйцэтгэлийн хөрөнгө анги	Сумдын байцаагч нарын үндэт цаас 1,906.5 мянган төгрөг, салбэр хэрэгслийн 55.0 мянган төгрөгийг тоолоогүй байна	1,961.55	1,961.55	1,961.55	УСНББОУС-1, 12, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйцэтгэж бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно	Албан шаардлага	<i>Хүрэн</i>			
4	Ажил гүйцэтгэлийн зардал анги	Батлагдсан төсвийн зардлын дүнд 10 аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллагаагүй, цайны материалд 1,294.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1,294.50	1,294.50	1,294.50	УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4	Засгийн газрын 2021 оны "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын "...үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчих, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"	Албан шаардлага	<i>Хүрэн</i>			
5	Ажил гүйцэтгэлийн хөрөнгө анги	Тайлант онд 2,202.4 мянган төгрөгийн худалдан авалтын и баримтыг илүү дутуу шилүүлснийг аудитын явцад зарцууллаа	2,202.41			УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.19	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйцэтгэж бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйцэтгэж бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хавлах, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дайгаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падааг үйлдэнэ."	залруулсан	<i>Хүрэн</i>			
						12,195.47	3,493.06	3,493.06				

Ахлах Аудитор: *Х.Түвшинбаяр* 2022.02.15  
 Алхан шатанд хянасан: *Д.Цэрэпханд* 2022.02.15  
 Аудитын менежер: *Д.Аюушпил* 2022.02.15  
 Хоёр дахь шатанд хянасан: *Х.Түвшинбаяр* 2022.02.15

УБХ-ын Дарга *Х.Түвшинбаяр*  
 Нягтлан бодох *Х.Түвшинбаяр*  
 Танилцаж зөвшөөрсөн: *Х.Түвшинбаяр* 2022.02.15  
 Б.Алтанбагана 2022.02.15  
 ГСТ7153 0521020012